

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮД, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР, ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 44 дүгээр тэмдэглэлд:

“22.1.Нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашид анхаарах асуудлын талаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, албан тушаалтанд даалгав:

1.Хот, суурин газрын агаарын чанар болон дотоод орчны агаарын чанарыг хянах, үнэлэхэд чиглэсэн “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016” стандартыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас өгсөн зөвлөмжийн хүрээнд, “Сайжруулсан хатуу түлшний техникийн ерөнхий шаардлага MNS5679:2022” стандартыг холбогдох хуулийн хүрээнд тус тус шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг хангуйлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа нарт;

2.Бүх төрлийн хийн түлшний халаалт бүхий өрхүүдэд хийн түлшний үнийн урамшуулалт олгох хувь, урамшууллын хэмжээг тогтоосон журмын төсөл, “Яндангүй бүс”-д бүх төрлийн хатуу түлш хэрэглэхийг хориглосон шийдвэрийн төслийг тус тус боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;

3.Нийслэлийн агаарын чанарын бүсэд хөдөлгөөнд оролцож байгаа нийтийн болон төрийн өмчийн байгууллагуудын тээврийн хэрэгсэлд Евро-5 ангиллын шатахуун ашиглах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т, Евро-5 ангиллын шатахууны нийлүүлэлтийг нэмэгдүүлж чанар, стандартыг мөрдүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваанд;

4.Хийн түлшний халаалтад шилжүүлэхээр төлөвлөсөн бүсийн өрхүүдэд хийн халаалтын тоног төхөөрөмжийг ногоон зээлээр авах боломжийг бүрдүүлж, шаардагдах дэмжлэгийг судлан холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;

5. Яндангүй бүсийн зураглал, хамрагдах өрхийн судалгааг гаргаж, яндангүй бүс тогтоож байгаа талаар олон нийтэд зарлан мэдээлэх, уг бүсэд хамрагдах өрхүүдийг эрчим хүчний хэмнэлт бүхий дулаан алдагдал багатай орон сууц, монгол гэрийн иж бүрэн дулаалга, хийн болон цахилгаан халаагуур, стандартын шаардлага хангасан давхар шаталтат зуух зэрэг ногоон зээлийн бүтээгдэхүүнээр хангах шийдвэрийн төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;

6. Агаарын чанарын бүсэд хууль бусаар түүхий нүүрс нэвтрүүлж, ашиглаж байгаа эсэхэд тавих хяналтыг чангатгаж, зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;

7. “Тавантолгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний чанар, аюулгүй байдлын стандарт, үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа, хяналтыг сайжруулах арга хэмжээ авч, үр дүнг тухай бүр танилцуулахыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;

8. Сайжруулсан шахмал түлшнээс үүдэлтэй угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд хүргэх сэрэмжлүүлэг, зөвлөмжийн хүртээмжтэй, үр дүнтэй байдалд анхаарч, мэдээлэх ажлыг эрчимжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд, агаарын бохирдлоос шалтгаалсан өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж танилцуулахыг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханд;

9. Цахилгаан халаагуураар халаах техникийн хүчин чадал нь 4квт байх боломжтой дүүрэг, хороодын айл өрхийг цахилгаан болон хийн халаалтад шилжүүлж, цахилгаан хангамжийн найдвартай байдлыг хангах, шөнийн тарифын хөнгөлөлтийн урамшуулалд хамруулах асуудлыг судалж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн сайд Б.Жавхлан нарт;

10. Нийслэлийн агаарын чанарын бүсэд зөвшөөрлийн дагуу түүхий нүүрс хэрэглэж байгаа төсвийн байгууллагуудын усан халаалтын зууханд технологийн шинэчлэл хийхэд шаардагдах санхүүжилтийг 2025 оны төсвийн багцдаа багтааж шийдвэрлэх арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Боловсролын сайд П.Наранбаяр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;

11. Агаар, орчны бохирдлын талаар холбогдох төрийн байгууллагуудын тоон болон чанарын үзүүлэлт бүхий мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн сан, нэгдсэн дашбоард үүсгэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд, холбогдох мэдээллийн үнэн зөв, бодит байдалд хяналт тавьж, тухай бүр шинэчилж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;

12.Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж, холбогдох албадын үйл ажиллагааг эрчимжүүлж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР